*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН В.ШООВДОРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт<br>Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.<br>(Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 4, 5, 6 дугаар зорилт) | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах, khutulbur.iaac.mn цахим хуудсанд тайлагнах | - Батлуулсан төлөвлөгөө;<br>- Хэрэгжилтийн хувь. | 97.5 | 50 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах 2 төлөвлөгөөг нэгжийн даргаар хянуулан, байгууллагын даргаар батлуулсан.<br>1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;<br>2. Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.<br>Баталсан төлөвлөгөөг төв, орон нутаг дахь нэгжийн дарга нарт Захиргаа, удирдлагын газрын 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/06 дотоод албан бичгээр цахимаар хүргүүлж, байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан.<br>Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын 2023 оны тайланг төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д албан хаагчдад нээлттэй байршуулсан.<br>Авлигатай тэмцэх газрын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх | 01-05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зорилтын хүрээнд эрхлэн гаргадаг Шударга ёс сэтгүүлд тус байгууллагын Дорноговь аймаг дахь газрын Дорноговь аймаг дахь ахлах мэргэжилтэн П.Гантулга "Авлигын мөн чанар, хор уршиг, Монголчуудын авлигатай тэмцсэн түүхэн уламжлал" сэдэвт илтгэл бичиж хүргүүлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих | - Батлуулсан төлөвлөгөө;<br>- Хэрэгжилтийн хувь. | 91.8 | 50 | Салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж батлуулсан, төлөвлөгөөг Захиргаа, удирдлагын газрын 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/07 дотоод албан бичгээр нэгжүүдэд цахимаар хүргүүлэв.<br>Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.20, 5.23-т заасны дагуу хувийн чөлөө хүссэн 75, сургалтад хамрагдах 3, гэр бүлд нь шинэ хүүхэд төрсөн 3, нийт 81 албан хаагчид 10-30 хүртэл хоногийн чөлөөг олгосон. Мөн журмын 7.4.1-т зааснаар гэр бүлийн гишүүн нь нас барсан 2 албан хаагчид 1,320,000 төгрөгийн тусламж ийг байгууллагын даргын Б/57, Б/134 дүгээр тушаалаар олгосон. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн, хуулийн 41.20-д "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурван сар ажилласанд тооцох ..." гэж заасны дагуу байгууллагын албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг жилийг нэг жил гурван сараар тооцогдохоор нэмэлт хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/357 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.<br>Төрийн тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн үзлэгт албан хаагчдыг хамруулах саналыг авч, 04 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн 11 төрлийн эрүүл | 01-05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн шинжилгээ, эмчийн үзлэгт төв байгууллагын 21 албан хаагчийг хамрууллаа.<br>Төрийн албаны тухай хуулийн 57.2.3, Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 160 дугаар тогтоолоор 2 дугаар хавсралтаар баталсан "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ"-г үндэслэн төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг байгууллагын даргын 04 дүгээр сарын 29-ний өдрийн Б/105 дугаар тушаалаар албан хаагчдыг шинээр томилохдоо хууль тогтоомжид заасан албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны нэмэгдлийг Засгийн газрын тогтоол хэрэгжиж эхлэх 04 дүгээр сарын 17-ны өдрөөс олгохоор шийдвэрлэсэн.<br>"Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар төв, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийг 34,000 төгрөг, унааны нөхөх төлбөрийг 1,000 төгрөгөөр шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай төсөл боловсруулан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх | - Боловсруулсан төсөл;<br>- Хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар. | - | 1 | 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар албан хаагчид төрийн тусгай албан хаагчийн ангилалд багтаж, хуулийн 41.14, 41.18-д Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газраас тогтооно гэж заасны дагуу Төрийн албаны хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын Засгийн газрын 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай" тогтоолоор байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр баталсан. | 02-05 | |

4

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гадаадын иргэн, харьяатын газрын орон тоонд өөрчлөлт оруулах санал (стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтцийн схем, орон тооны хуваарилалт,танилцуулга)-ыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/811 албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаал батлагдсан. Мөн байгууллагын даргын Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн зохион байгуулалтын нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай А/157, Гадаадын иргэн, харьяатын газрын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай А/158 дугаар тушаалыг тус тус баталлаа. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4. Сул орон тоог нээлттэй зарлуулж, тусгай шалгалтыг зохион байгуулан албан тушаалын сул орон тоог нөхөх | - Зарлуулсан сул орон тоо;<br>- Зохион байгуулсан тусгай шалгалтын тоо;<br>- Нэр дэвшүүлж, нөхсөн албан тушаал;<br>- ТАЗ-д хүргүүлсэн цахим тайлан. | Сул орон тоо-32; Тусгай шалгалт-8; Нөхсөн орон тоо-21; Цахим тайлан-8. | 50 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд эхний хагас жилийн дүнгээр салбар зөвлөлөөс 2 удаа удирдах 1, гүйцэтгэх 7 албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар "Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар"-ыг нээлттэй байршуулж, нөхөгдөөгүй сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлсэн.<br>Дээрх 2 удаагийн зарын дагуу 7 иргэн shalgalt@immigration.gov.mn цахим хаягаар Захиргаа, удирдлагын газарт нийслэлийн Газар, зохион байгуулалтын албанаас төрийн захиргааны дэс түшмэлийн 1, Дорноговь аймаг дахь газарт төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, Баруун бүс дэх газарт Увс аймаг дахь хэлтсээс төрийн жинхэнэ албан хаагч 1, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, нийт 4 мэргэжилтний албан тушаалд хүсэлт ирүүлсэн.Үүнээс тухайн албан тушаалын тодорхойлолт болон шаардлага хангасан 2 төрийн | 01-05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жинхэнэ албан хаагчийг Захиргаа, удирдлагын газарт хуулийн мэргэжилтэн, Баруун бүс дэх газарт мэргэжилтнээр тус тус шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн бол төрийн тусгай байгууллагад ажиллаж байгаа 2 төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд 1 нь шийдвэрлэгдэх шатандаа, 1-ийг нь үндсэн байгууллага шилжүүлэх зөвшилцөлд хүрээгүй тул хүсэлтийг шийдвэрлээгүй.<br>Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2024 оны 1 дүгээр улиралд салбар зөвлөлийн 01, 06, 11 дүгээр тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комисс байгуулж, төрийн захиргааны удирдах 1, гүйцэтгэх 5 албан тушаалын сул орон тоо нөхөх 2 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа. Тусгай шалгалтад тэнцсэн иргэдийн 3 буюу 50.0 хувь нь 2021-2023 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд, 2 буюу 33.3 хувь төрийн жинхэнэ албан хаагч, нээлттэй зарлуулсан 6 сул орон тооноос 1 буюу 16.6 хувь нөхөгдөөгүй.<br>Хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан тушаал, зарим төрийн үйлчилгээний албан тушаалууд төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан мэдээллийн технологийн болон санхүүгийн чиг үүрэг хэрэгжүүлдэг 16 албан хаагчийг тусгай шалгалтад хамруулах захиалгыг салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр хүргүүлсэн бөгөөд АТТ батлуулсны дараа зохион байгуулахаар хүлээгдэж байна. | | |
| 5. | Арга хэмжээ 1.5. Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих | - Батлуулсан төлөвлөгөө;<br>- Хэрэгжилтийн хувь | 99.3 | 50 | Салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, батлуулсан.<br>Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжилтний боловсруулсан удирдамж, сургалтын хөтөлбөр, илтгэх хуудас зэргийг тухай бүр хянаж байна.<br>Төлөвлөгөөний дагуу "Удирдах албан тушаалтны нэгдсэн цугларалт", "Хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалт", "Зөвлөгөө мэдээллийн 1800-1882 утсаар | 01-05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөгөө мэдээлэл хүргэх албан хаагчдыг дадлагажуулах сургалт", "Монгол хүний сэтгэлгээ ба хандлага", "Утсаар үр дүнтэй харилцах ур чадвар", "Эрүүл амьдралын зөв дадал, зуршил" зэрэг сургалтыг зохион байгуулсан. Мөн Десерет олон улсын байгууллагатай хамтран албан хаагчдын англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт, Эмэгтэйчүүдийн манлайлал, Орон нутаг дахь газар, хэлтсийн захиргааны ахлах мэргэжилтэн, бичиг хэргийн эрхлэгч нарын нэгдсэн цугларалт, Полиси төвтэй хамтран "Байгууллагын соёл", Ёс зүйгээр байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь, шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт, Хүүхэд хүмүүжлийн зөрөг арга зэрэг сургалтуудыг зохион байгууллаа. Дээрх сургалтуудад давхардсан тоогоор 700 гаруй албан хаагчийг хамрууллаа.<br>Гадаад сургалтад БНЭУ-д хүний нөөцийн чиглэлээр 1, хэлний мэдлэг дээшлүүлэх 1, Унгар улсад 3, БНСУ-д 18, АНУ-д 2 албан хаагчийг сургалтад хамруулсан. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. Удирдах ажилтан, хяналтын улсын ахлах байцаагч, захиргааны ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагчийн эрх олгох, зөвлөгөө мэдээллийн чиг үүрэг хэрэгжүүлэх албан хаагчдад зорилтот сургалт зохион байгуулах, хяналт тавих | - Батлуулсан удирдамж, сургалтын хөтөлбөр;<br>- Хэрэгжилтийн хувь | - | 50 | Байгууллагын даргын 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар 01 дүгээр сарын 10-14-ний өдрүүдэд "Удирдах албан тушаалтны нэгдсэн цугларалт"-ыг Улаанбаатар хот, Дорноговь аймаг дахь газарт тус тус зохион байгууллаа. Уг цугларалтад 30 албан хаагч хамрагдсан.<br>Байгууллагын даргын 02 дугаар сарын 14-ний өдрийн 01-02/07 дугаар удирдамжийн дагуу 02 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд "Хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалт"-ыг Зөрчил шалган шийдвэрлэх газартай хамтран зохион байгууллаа. Уг сургалтад 12 хяналтын улсын байцаагч, хяналтын улсын байцаагчийн орон тоонд ажиллаж буй 6 мэргэжилтэн хамрагдсан.<br>Байгууллагын даргын 02 дугаар сарын 15-ны өдрийн 01-02/09 дүгээр удирдамжийн дагуу зөвлөгөө мэдээллийн 1800-1882 утсаар зөвлөгөө мэдээлэл хүргэх албан хаагчдыг дадлагажуулах сургалтад орон нутаг дахь нэгжийн 16 албан хаагчийг 02 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд танхимын сургалтад хамрууллаа. | 01-03 | |
| 7. | Арга хэмжээ 1.7. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарах | - Салбар зөвлөлийн | Тангараг өргөх ёслол 2 удаа; | - | Тангараг өргөх ёслолын ажиллагааг 07 дугаар сарын 03-ны өдөр буюу Төрийн албаны өдрийг тохиолдуулан зохион байгуулах юм. | - | ХХБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах | тогтоолын огноо, дугаар;<br>- Хамрагдсан албан хаагчийн тоо. | Албан хаагч-14. | | | | |
| 8. | Арга хэмжээ 1.8. Албан тушаалд шинээр томилох, шилжүүлэн ажиллуулахтай холбогдуулан ХАСУМ хянуулах, 2023 оны тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх | - ХАСУМ мэдүүлсэн албан хаагчийн тоо;<br>- Тайлан хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар. | ХАСУМ-78; ХАСХОМ-201 | 100 | Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 37 албан хаагч, иргэний материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж хэвшлээ. Үүнд:<br>- Төрийн бусад байгууллагаас шилжүүлэн ажиллуулах-6<br>- Нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах-5<br>- Шинээр томилогдох-10<br>- Дэвшүүлэн томилох-10<br>- Түр орлон гүйцэтгэгчээр томилох-5<br>- Үргэлжлүүлэн ажиллуулах-1.<br>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем"-д үүсгэсэн мэдүүлэг гаргагч нийт албан тушаалтнуудын 2023 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж, "ХАСХОМ-ийн 2023 оны тайлан"-г батлагдсан маягт, зөвлөмж зааврын дагуу нэгтгэж хавсралтаар, ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй тайланг системээс уншуулж, цахимаар хүргүүлсэн тухай байгууллагын даргын 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/427 албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.<br>"Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бүртгэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийн дагуу тайлант хугацаанд 122 албан хаагчийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулж, "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем"-д бүртгэлээ. | 01-05 | |
| 9. | Арга хэмжээ 1.9. Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх | - Батлагдсан төлөвлөгөө;<br>- Хэрэгжилтийн хувь. | 100 | 50 | Салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, салбар зөвлөлийн 05 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 01-05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах | | | | Тайлант хугацаанд салбар зөвлөлөөс 2 удаагийн сонгон шалгаруулалт зохион байгуулах захиалга хүргүүлэх албан бичиг 4, төлөвлөгөө батлах 1, тусгай шалгалтын комисс байгуулах тогтоол 3, сонгон шалгаруулалтад тэнцсэн 7 иргэн, 2 албан хаагчийг нэр дэвшүүлсэн, 1 иргэнийг нөхөн бүртгэсэн 1, урамшуулал олгох 1, нийт 15 тогтоол тус тус баталсан.<br>Салбар зөвлөлөөс 1 дүгээр улиралд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын цахим хуудсаар нийтэд, erp.e-mongolia.mn цахим сүлжээгээр нийт албан хаагчдад нээлттэй танилцуулсан.<br>Салбар зөвлөлийн эхний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх юм. | | |
| 10. | Арга хэмжээ 1.10. Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулахад сонсох ажиллагаа хийсэн байх | - Сонсох ажиллагаанд хамрагдсан албан хаагчийн тоо;<br>- Боловсруулж, батлуулсан тушаалын тоо. | Сахилгын шийтгэл-25; Сэлгэн-2; Бусад байгууллагад шилжсэн-4. | 100 | Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах 4, төрийн бусад байгууллагад сэлгэн ажиллаж байгаад үндсэн албан тушаалд үргэлжлүүлэн ажиллах 1, нийт 5 төрийн жинхэнэ албан хаагчтай Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийж, тэмдэглэлийг албажуулсан. | 01-05 | |
| 11. | Арга хэмжээ 1.11. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хүлээн авсан албан бичиг, хариутай албан бичиг, албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариуг өгөх, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх | - edoc.mojha.gov.mn цахим системээр хүлээн авсан баримт бичиг, өргөдөл гомдлын тоо;<br>- Шийдвэрлэлтийн хувь;<br>- Хянасан тушаал, төлөвлөгөө, удирдамж, албан бичгийн төслийн тоо. | 100 | 100 | Тайлант хугацаанд хариуцсан чиг үүргийн дагуу А-тушаал 5, Б-тушаал 56, төлөвлөгөө 3, албан бичиг 77, илтгэх хуудас 19, дотоод албан бичиг 9-г тус тус боловсруулж, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж батлуулсан.<br>Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн боловсруулсан нийт А-тушаал 11, Б-тушаал 71, 12 удирдамж, хөтөлбөр, 24 илтгэх хуудас, дотоод албан бичиг 10, бусад төрийн байгууллагад явуулах 83 албан бичгийн төслийг тухай бүр хянаж, албан бичгийн стандарт болон монгол хэл бичгийн найруулга зүй, зөв бичгийн дүрмийн алдааг засаж, залруулсан.<br>Тайлант хугацаанд бие даан 18 албан хаагч, 3 иргэний, нийт 21 өргөдөл, хүний нөөцийн дүнгээр 47 албан хаагч, 15 иргэний, нийт 62 өргөдлийг хүлээн авч, 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг холбогдох иргэн, | 01-05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан хаагчид тухай бүр албан бичгээр болон амаар өгсөн. | | |
| Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт<br>Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.<br>(Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3 дугаар зорилт) | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3-т заасан мэдээллийн нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр www.immigration.gov.mn цахим хуудсанд байршуулсан байх | Байршуулсан мэдээлэл | Тухай бүр | 100 | Хүний нөөцийн талаарх хуульд заасан 6 төрлийн мэдээлэлд дараах байдлаар нэмэлт мэдээлэл оруулсан.<br>1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл-ТАЗ-ын цахим хуудас руу шууд холбогддог бөгөөд 2 удаагийн нээлттэй зар, төрийн жинхэнэ албан хаагчийг шилжин, сэлгэн ажиллуулах 3 удаагийн зар;<br>2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам-ТАЗ-ын 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ыг байгууллагын цахим хуудасны "хүний нөөц"-"хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, холбогдох журам" цэсэд нэмэлтээр;<br>3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм- "хүний нөөц"-"хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, холбогдох журам" цэсэд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг нэмэлтээр;<br>4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам-<br>5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ- Салбар зөвлөлийн 2024 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын цахим хуудасны "хүний нөөц"-"тайлан" цэсэд нэмэлтээр;<br>6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам-Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг нэмэлтээр; | 01-05 | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны явц, үр дүнг албан хаагчдад мэдээлэх | Байршуулсан мэдээлэл | 4 | 4 | Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт, сул орон тоог нөхсөн тухай 1 дүгээр улирлын үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд байршуулсан.<br>Мөн уг мэдээллийг төв, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад нээлттэй танилцуулах зорилгоор егр.e-mongolia.mn цахим сүлжээнд байршууллаа. | 01-03 | |

13

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2 дугаар улирлын үйл ажиллагааны мэдээллийг Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлийн эхний хагас жилийн тайлан хүргүүлсний дараа мэдээлэх юм. | | |
| 3. | Арга хэмжээ 2.3. Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний мэдээллийг албан хаагчдад танилцуулах | Байршуулсан мэдээлэл | 1 | - | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | 12 | ХХБ |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Албан тушаалын тодорхойлолт шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах | - Боловсруулж, хянасан албан тушаалын тодорхойлолтын тоо;<br>- Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар. | - | 100 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуульд Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байхаар тус тус зохицуулсны дагуу байгууллагын даргын 02 дугаар сарын 07-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулж, шинээр болон шинэчлэн боловсруулах албан тушаалын тодорхойлолтод холбогдох газар, хэлтсийн дарга, албан хаагчдаас санал авах ажлыг зохион байгуулж, эхний хувилбарыг боловсруулсан.<br>Төрийн албаны тухай хуулийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам", тухайн албан тушаалд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулалтыг эцэслэсэн Шинээр 16, шинэчлэн боловсруулсан 60, нийт 76 төрийн тусгай албан тушаалын тодорхойлолтуудыг хянуулж, зөвшөөрөл хүсэх тухай байгууллагын даргын 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1056 дугаар албан бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. | 02-06 | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | - Боловсруулсан журмын төсөл | - | 100 | Төрийн албаны тухай хуулийн 57.2.3, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.1, Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 160 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Гадаадын иргэний | 04-05 | |

41

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мэргэшлийн зэрэг олгох журмын төсөл боловсруулах | | | | асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ", уг журмын 5.1, 5.2, 5.3-т заасныг үндэслэн "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам"-ын төслийг шинээр боловсруулсан.<br>Журмын төсөлд санал авах ажлыг 05 дугаар сарын 15-ны өдрийн 02/30 дугаар дотоод албан бичгээр төв болон хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлж, Захиргаа, удирдлагын газар, Виз, зөвшөөрлийн газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс, Агаарын замын боомт хариуцсан газар, Дорноговь аймаг дахь газар, Баруун бүс дэх газар, Хойд бүс дэх газар, Өмнөд бүс дэх газар, Зүүн бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс зэрэг 11 нэгжээс санал ирүүлснийг тусган 06 дугаар сарын 03-ны өдрийн 01-02/82 илтгэх хуудсаар удирдлагад танилцуулахаар өгсөн. | | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Хоол, унааны нөхөх төлбөр шинэчлэн тогтоох асуудлаар судалгаа хийх, холбогдох шийдвэр батлуулах | - Боловсруулсан илтгэх хуудасны огноо, дугаар;<br>- Батлуулсан тушаалын огноо, дугаар. | - | 100 | Төрийн албаны тухай хуулийн 59.1.8, 61.1, 61.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1.1, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.4, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.10, "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн 3.9-д заасны дагуу төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын хоолны нөхөх төлбөрийг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судалсан дүн, холбогдох саналыг 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01-02/55 илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулсан.<br>Хууль тогтоомж, санхүүгийн эх үүсвэрт нийцүүлэн байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар хоолны нөхөх төлбөрийг 34,000, унааны нөхөх төлбөрийг 1,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн. | 03-04 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. “Монгол бичиг”-ийн цахим сургалтад хамрагдах | - 1, 2, 3-р түвшний сургалтад хамрагдсан байх;<br>- Гэрчилгээ авсан байх. | - | 100 | Удирдлагын академи, Төрийн албаны сургуулийн Монгол бичгийн анхан, дунд, ахисан түвшний 1-3 дугаар шатны цахим сургалтад 03 дугаар сарын 19, 27, 06 дугаар сарын 05-ны өдөр шалгалт өгч, 70 буюу түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй тэнцэж, гэрчилгээ авсан. | 03-06 | |
| 2. | Арга хэмжээ 2. “Авлигаас ангид төрийн алба” цахим сургалтад хамрагдах | - 1, 2, 3-р түвшний сургалтад хамрагдсан байх;<br>- Гэрчилгээ авсан байх. | - | - | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | | ХХБ |
| 3. | Арга хэмжээ 3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд шинээр томилогдсон албан хаагчдад сургалт зохион байгуулах | - Чиглүүлэх сургалтын тоо;<br>- Хамрагдсан албан хаагчийн тоо | 3 удаа, 31 албан хаагч | 50 | Байгууллагын даргын 05 дугаар сарын 06-ны өдрийн 01-02/25 дугаар удирдамжийн дагуу 05 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд байгууллагад шинээр болон төрийн бусад байгууллагаас шилжин томилогдсон албан хаагчдад байгууллагын чиг үүрэг, онцлогийг таниулах чиглүүлэх 11 албан хаагч хамрагдсан сургалтад Төрийн албаны тухай хууль тогтоомж, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, www.medeeleg.iaac.mn цахим системийн ашиглалт, төрийн жинхэнэ албан хаагчийн үүрэг, хариуцлага, анхаарах асуудал 4 сэдвээр сургалт хийлээ. | 05 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн
*( Албан тушаал )*

/В.Шоовдор/
*( Нэр, гарын үсэг )*

2024.06.06.
*( Огноо )*

96

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН В.ШООВДОРЫН 2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт<br>Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.<br>(Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 4, 5, 6 дугаар зорилт) | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах, khutulbur.iaac.mn цахим хуудсанд тайлагнах | - Батлуулсан төлөвлөгөө;<br>- Хэрэгжилтийн хувь. | 97.5 | 100 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах 2 төлөвлөгөөг нэгжийн даргаар хянуулан, байгууллагын даргаар батлуулсан.<br>1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;<br>2. Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.<br>Баталсан төлөвлөгөөг төв, орон нутаг дахь нэгжийн дарга нарт Захиргаа, удирдлагын газрын 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/06 дотоод албан бичгээр цахимаар хүргүүлж, байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан.<br>Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 75 албан хаагч, иргэний баримт бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргасан.<br>Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын | 01-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ерөнхий нөхцөл байдлын 2023 оны тайланг төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д албан хаагчдад нээлттэй байршуулсан.<br>Авлигатай тэмцэх газрын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд эрхлэн гаргадаг Шударга ёс сэтгүүлд Дорноговь аймаг дахь газрын ахлах мэргэжилтэн, /ХУБ/, ахлах зөвлөх, докторант П.Гантулга "АВЛИГЫН МӨН ЧАНАР, ХОР УРШИГ, МОНГОЛЧУУДЫН ТҮҮНТЭЙ ТЭМЦСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ" сэдэвт илтгэлээр амжилттай оролцож, "Шударга ёс" онол, арга зүй, мэдээллийн хагас жил тутмын цуврал сэтгүүлийн 2024/01/27 дугаарт уг илтгэл нийтлэгдсэн<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 11 дүгээр сарын 21-ний өдөр ХШҮАХ-т хүргүүлж, гүйцэтгэлийг 92 хувьтай үнэлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих | - Батлуулсан төлөвлөгөө;<br>- Хэрэгжилтийн хувь. | 91.8 | 100 | Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөө"-г батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт эхний 11 сарын дүнгээр 90 хувьтай үнэлэгдсэн.<br>"Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг жил гурван сар ажилласанд тооцуулж, хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/357 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.<br>Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл төрийн тусгай албан тушаалд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай | 01-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
